



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК ТӨААТҮГ-ЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/18/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэ
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Аудитор: Д.Болормаа
Утас: 51-261740 Цахим хаяг: bolormaad@audit.gov.mn
Азуре хүлүг аудит ХХК-ийн захирал: Г.Мөнхбаяр
Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Төрийн өмчит үйлдвэрийн газар, түүний үйл ажиллагаа	9
3.2 Төрийн өмчит үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	14
5.2 Албан шаардлага	14
5.3 Зөвлөмж	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.14 № 07/665
танай _____-ны № _____-т

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
ҮНДЭСНИЙ ПАРК ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ж.ЗОЛЗАЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 502.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 482.4 сая төгрөгөөр давсан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.3, 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3-т заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, тасалбар болголт, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд өөрийн хөрөнгөөр 37.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, ТӨБЗГ-ын 2023 оны 541 дүгээр тогтоолын дагуу 36 нэрийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, 36.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон, ТӨБЗГ-ын 2023 оны 553 дугаар тогтоолын дагуу 59 нэрийн 938.1 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Аудитын гол асуудал

Тус үйлдвэрийн газар нь ICT Expo-2023 арга хэмжээний ерөнхий зохион байгуулагчаар ажиллаж, үйл ажиллагаанаас 414.9 сая төгрөгийн нэмэлт орлогыг олсон байна.

Бусад асуудлын хэсэг

Үйлдвэрийн газрын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 64 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Цахим шилжилт"-ийг эрчимжүүлэх ажлын хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "ICT Expo-2023" арга хэмжээний ерөнхий зохион байгуулагчаар ажилласан байна. Энэхүү арга хэмжээнд олон улсын болон дотоодын 190 орчим байгууллагыг оролцуулан тэдгээр байгууллагын хооронд 4,900.0 сая төгрөгийн 885 гэрээ хэлэлцээр баталгаажихад дэмжлэг үзүүлж, оролцогч байгууллагуудын 492 шинэ технологийн мэдээллийг цахим болон биет байдлаар 2.6 сая иргэнд хүргэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10,016,223.52	3,383,133.82
1.1.2	Дансны авлага	179,190,161.24	224,758,843.59
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	40,974,592.44	30,878,159.91
1.1.4	Бусад авлага	3,783,367.40	88,244,311.00
1.1.6	Бараа материал	127,956,967.25	120,989,265.12
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	17,481.00	500,028.02
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	361,938,792.86	468,753,741.46
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,119,977,806.30	3,766,260,887.40
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,119,977,806.30	3,766,260,887.40
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,481,916,599.15	4,235,014,628.86
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	36,161,000.00	76,679,479.73
2.1.1.2	Цалингийн өглөг	-	111,331.00
2.1.1.3	Татварын өр	21,300,060.93	3,581,903.36
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	775,702,438.71	736,658,876.11
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	13,988,573.80	13,001,327.51
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	847,152,073.43	830,032,917.71
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	3,334,457.15	2,828,390.70
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,334,457.15	2,828,390.70
2.2	Өр төлбөрийн нийт дүн	850,486,530.58	832,861,308.41
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	1,021,630,200.00	1,021,630,200.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,207,725,219.64	3,042,193,559.47
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	789,494,381.42	789,494,381.42
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,387,419,732.49)	(1,451,164,820.43)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	3,631,430,068.57	3,402,153,320.46
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	4,481,916,599.15	4,235,014,628.86

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	864,277,750.19	908,941,302.88
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	18,427,166.89	21,547,844.10
3	Нийт ашиг (алдагдал)	845,850,583.30	887,393,458.78
4	Түрээсийн орлого	-	414,968,508.81
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	803,037,596.40	664,169,287.07
9	Борлуулалт, маркетингийн зардал	315,868,771.42	146,244,981.52
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,331,494,625.04	2,019,765,734.34
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	1,767,614.09	(1,695,034.34)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(8,140.95)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	3,292,397.33	(201,182,636.49)
19	Орлогын татварын зардал	329,239.73	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,963,157.60	(201,182,636.49)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	2,963,157.60	(201,182,636.49)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
26	Бусад олз (гарз)	-	-
27	Орлогын нийт дүн	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусаар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,021,630,200.00	3,207,725,219.64	789,494,381.42	(1,460,666,516.68)	3,558,183,284.38
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	70,283,626.58	70,283,626.58
Залруулсан үлдэгдэл	1,021,630,200.00	3,207,725,219.64	789,494,381.42	(1,390,382,890.10)	3,628,466,910.96
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	2,963,157.60	2,963,157.60
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлээний нэмэгдэл	-	-	-	-	-
2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,021,630,200.00	3,207,725,219.64	789,494,381.42	(1,387,419,732.49)	3,631,430,068.57
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	137,437,548.56	137,437,548.56
Залруулсан үлдэгдэл	1,021,630,200.00	3,207,725,219.64	789,494,381.42	(1,249,982,183.94)	3,768,867,617.13
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(201,182,636.49)	(201,182,636.49)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлээний нэмэгдэл	-	(165,531,660.18)	-	-	(165,531,660.18)
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,021,630,200.00	3,042,193,559.47	789,494,381.42	(1,451,164,820.43)	3,402,153,320.46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,510,552,183.13	1,886,188,471.18
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	902,875,749.73	1,066,840,898.22
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,001,544.00	848,217.00
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	606,674,889.40	818,499,355.96
1.2	Мөнгөн зарлага (-)	1,485,341,324.19	1,865,466,787.88
	Ажиллагчдад төлсөн	417,342,003.00	587,528,697.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	133,663,051.57	178,983,321.58
	Бараа материал худалдан авахад төлсөн	81,907,975.50	67,675,564.00
	Ашиглалтын зардалд төлсөн	134,726,923.73	154,122,381.37
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,219,820.00	9,887,000.00
	Татварын байгууллагад төлсөн	252,610,562.09	197,842,899.76
	Даатгалын төлбөрт төлсөн	1,712,774.00	956,767.00
	Бусад мөнгөн зарлага	454,158,214.30	668,470,157.17
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	25,210,858.94	20,721,683.30
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	21,842,951.21	35,784,231.60
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	21,842,951.21	35,784,231.60
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	50,921,662.15	50,871,882.60
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	22,516,950.00	29,574,450.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	28,404,712.15	21,297,432.60
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(29,078,710.94)	(15,087,651.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	14,184,450.00	113,841,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	14,184,450.00	113,341,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	500,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,907,250.00	126,108,122.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,907,250.00	124,626,572.00
	Төлсөн ногдол ашиг	-	1,481,550.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	12,277,200.00	(12,267,122.00)
3.4	Валютын ханшийн зөрүү	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	8,409,348.00	(6,633,089.70)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,606,875.52	10,016,223.52
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,016,223.52	3,383,133.82

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 оны Гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	2	3	4	5	6	7	8
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
	Түрээсийн орлого	мян.төг	810,107.6	1,291,730.2	837,119.4	(454,610.8)	64.8
	Бусад орлого	мян.төг	33,332.5	42,519.6	45,340.7	2,821.1	106.6
	Бусад орлого /ЭКСПО/	мян.төг	-	-	414,968.5	414,968.5	-
	Сургалт, шалгалт, төсөл хөтөлбөрийн орлого	мян.төг	299,758.3	904,624.6	214,103.0	(690,521.5)	23.7
1	Инкубаторын үйл ажиллагааны орлого	мян.төг	4,469.7	284,643.0	219,541.6	(65,101.4)	77.1
	"Эко систем" хөтөлбөрийн орлого	мян.төг	238,175.1	145,040.0	223,426.0	78,386.0	154.0
	Технологи дамжуулах төвийн орлого	мян.төг	22,605.3	25,454.6	26,481.2	1,026.6	104.0
	Хандив тусламжийн орлого	мян.төг	260,634.5	105,926.5	219,140.3	113,213.7	206.9
2	Нийт орлого	мян.төг	1,669,083.0	2,799,938.4	2,200,120.7	(599,817.7)	78.6
	Цэвэр борлуулалт	мян.төг	1,669,083.0	2,799,938.4	2,200,120.7	(599,817.7)	78.6
3	Нийт зардал	мян.төг	1,665,790.6	2,795,474.9	2,401,303.3	(394,171.6)	85.9
3.1	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	119,571.9	117,275.4	158,832.6	41,557.2	135.4
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	3,292.4	4,463.5	(201,182.6)	(196,719.1)	(4,507.3)
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	2,963.2	4,017.2	(201,182.6)	(197,165.5)	(5,008.1)
6	Төсвийн төлбөр	мян.төг	399,557.7	542,138.8	396,356.4	(145,782.4)	73.1
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	1,050.0	2,008.6	1,481.6	(527.0)	73.8
8	Ажиллагсдын тоо	хүн	37	37	37	-	100.0
9	Нийт цалингийн сан	мян.төг	472,541.6	740,307.0	644,330.0	(95,977.0)	87.0
10	Нэг ажилтны сарын дундаж цалин	мян.төг	1,064.3	1,667.4	1,451.2	(216.2)	87.0
11	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.0	1.0	0.9	(0.1)	91.5
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	22,457.0	318,258.6	37,768.9	(280,489.7)	11.9
13	Нийт авлага	мян.төг	223,948.1	82,087.6	343,881.3	261,793.7	418.9
14	Нийт өглөг	мян.төг	850,486.5	327,927.8	832,861.3	504,933.5	254.0
14.1	Үүнээс: богино хугацаат өр төлбөрт	мян.төг	71,449.6	99,807.6	93,374.0	(6,433.5)	93.6
14.2	Урт хугацаат өр төлбөрт	мян.төг	3,334.5	2,816.2	2,828.4	12.2	100.4
14.2.3	Бусад /УОО/	мян.төг	775,702.4	225,304.1	736,658.9	511,354.8	327.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төрийн өмчит үйлдвэрийн газар, түүний үйл ажиллагаа

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын зорилго нь төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаанд суурилсан инновацийн тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах өрсөлдөх чадвар бүхий үндэсний компаниудыг төлөвшүүлэх, мэдээллийн технологийн өндөр ур чадвартай боловсон хүчнийг хөгжүүлэхэд оршино.

Тус үйлдвэрийн газрын дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Харилцаа холбооны дэвшилтэт технологийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын болон инновацийн судалгаа, хөгжүүлэлт хийх;
- Инновацийн үйл ажиллагаа, гарааны бизнесийг дэмжих;
- Мэдээллийн технологийн чадварыг сайжруулах;
- Үйлдвэрийн газар нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг явуулахад холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлснээр тухай үйл ажиллагааг эрхэлнэ.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын дүрэмд зааснаар өмчийг 100 хувь төр эзэмшиж байгаа бөгөөд төрийн өмчийн төлөөллийг Засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага болох Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлэхээр заасан байна.

3.2 Төрийн өмчит үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчин

Үйлдвэрийн газрын үйл ажиллагааг явуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын Иргэний хууль, Инновацийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Харилцаа холбоотой тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 05 сарын 04-ний өдрийн “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 10 дугаар тогтоол;
- Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын захирлын 2023 оны А/32 тоот тушаал “Инкубаторын дараах үйлчилгээний журам батлах тухай”
- Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын захирлын 2023 оны А/58 тоот тушаал “Сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”

Үйлдвэрийн газрын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Үйлдвэрийн газар нь дотоод аудитын нэгжгүй, дээд шатны төсвийн захирагч болох Цахим хөгжил, харилцаа холбооны яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шалгалт хийдэг бөгөөд 2022-2023 оны 3 дугаар улирлын байдлаарх үйл ажиллагаанд шалгалт хийж худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд заасан хугацаанд тендер шалгаруулалтыг зохион байгуулах талаар зөвлөмж өгч ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Гүйцэтгэх захирлын 2019 оны 1а-02 тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 353.7 сая төгрөгөөр буюу 5.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянаан төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,016.2	3,383.1	(6,633.1)
Авлага	223,948.1	343,881.3	119,933.2
Бараа материал	127,957.0	120,989.3	(6,967.7)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	17.5	500.0	482.5
Үндсэн хөрөнгө	4,119,977.8	3,766,260.9	(353,716.9)
Нийт хөрөнгө	4,481,916.6	4,235,014.6	(246,902.0)
Өр төлбөр	850,486.5	832,861.3	(17,625.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,631,430.1	3,402,153.3	(229,276.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,481,916.6	4,235,014.6	(246,902.0)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцооны данснууд байна. Тухайлбал,

- Авлагын үлдэгдэл нь 343.9 сая төгрөг болж, өмнөх оноос 119.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд үйл ажиллагаатай холбоотой 1,611.7 сая төгрөгийн авлага үүсгэж, 1,481.7 сая төгрөгийн авлага цуглуулснаас шалтгаалсан;

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь 3,766.3 сая төгрөг болж, өмнөх оноос 353.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 33.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3.5 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, ТӨБЗГ-ын 2023 оны 541 дүгээр тогтоолын дагуу 36 нэрийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 36.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон, ТӨБЗГ-ын 2023 оны 553 дугаар тогтоолын дагуу 59 нэрийн 938.1 сая төгрөгийн хөрөнгийг акталж, тайлант хугацааны элэгдлийн зардалд 424.3 сая төгрөгийг бүртгэсэн зэргээс нөлөөлсөн;
- Засгийн газрын хувь оролцооны дансны үлдэгдэл нь 3,402.2 сая төгрөг болж, өмнөх оноос 229.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны алдагдал 201.2 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2023 оны 843 дугаар тогтоолын дагуу 39.5 сая төгрөгийн түрээсийн тооцооны өр, ТӨБЗГ-ын 2023 оны 541, 553 дугаар тогтоолтой холбоотойгоор хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд 165.5 сая төгрөгийн тохируулах бичилт хийсэн зэргээс голлон нөлөөлжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2022 оны 564 дүгээр тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 2,799.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,795.5 сая төгрөгөөр, 4.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 318.3 сая төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 2,200.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,401.3 сая төгрөгийн зардал гарган, 201.2 сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2,200.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 599.8 сая төгрөг буюу 21.4 хувиар тасарсан нь түрээсийн орлого 454.6 сая төгрөг, сургалт, шалгалт төсөл хөтөлбөрийн орлого 690.5 сая төгрөг, инкубаторын үйл ажиллагааны орлого 65.1 сая төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй гарснаас шалтгаалсан бол хандив тусламжийн орлого 113.2 сая төгрөгөөр даваж, төлөвлөгөөнд тусаагүй ICT экспо зохион байгуулах үйл ажиллагааны орлогоос 414.9 сая төгрөгийг олсон байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,401.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 394.2 сая төгрөг буюу 14.1 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл 280.5 сая төгрөг, цалингийн зардал, томилолтын зардал, урсгал засвар, сэлбэгийн хэрэгслийн зардал 134.1 сая төгрөгөөр хэмнэлттэй гарсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 4 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 37.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд 4.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар баталсан боловч гүйцэтгэлээр 201.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь түрээсийн орлого 454.6 сая төгрөг, сургалт, шалгалт, төсөл хөтөлбөрийн орлого 690.5 сая төгрөгөөр тасарснаас тус тус шалтгаалсан байна.

ТӨБЗГ-т тайлант онд ногдол ашгийн 1.5 сая төгрөг, түрээсийн орлогын 11.1 сая төгрөгийг тус тус төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах анхан шатны баримт бүрдэл, санхүүгийн тайлангийн тодруулгатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Азуре Хүлүг Аудит ХХК-ийн аудитын менежер Ч.Насанбат, туслах аудитор Г.Баасанбат, Б.Оджаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтын мэргэжилтэн П.Болортуяа, гүйцэтгэх захирал Г.Мөнхбаяр нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор Д.Болормаа, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг нар тус тус хэрэгжүүлсэн.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/39 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 1,648.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 16.5 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж, суурь үзүүлэлт нь өмнөх оны дүнгээс 19.1 хувиар өссөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэв.

Гүйцэтгэлийн үе шатанд 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын гүйцэтгэл 1,988.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 19.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага өдөр тутмын үйл ажиллагааг хуульд нийцүүлэн зохион байгуулж, үйлчлүүлэгч, харилцагч нарт энгийн шуурхай үйлчилж, байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаа зах зээлийн хамгийн хямд худалдан авалтыг хийх, үр дүнтэй байлгах арга хэмжээ авсан байна. Азийн шинжлэх ухааны паркуудын зөвлөлдөх уулзалтад оролцох гадаад томилолтын зардалд 8.2 сая төгрөгийн зардал гаргаж, хуульд заасны дагуу үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст байршуулбал зохих цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 1,655.9 сая төгрөгийн 133 ажил гүйлгээнээс 118.9 сая төгрөгийн 13 ажил гүйлгээг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, шилэн дансны цахим хуудаст мэдээллийг дутуу байршуулсан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон 3.3 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 5.8 сая төгрөгийн авлагатай холбоотой асуудалд албан шаардлага, томилолтын зардлын тооцоо, хяналттай холбоотой зөрчилд 1 зөвлөмжийг өгснийг 100.0 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3,332.0	1	3,332.0	100.0
Албан шаардлага	1	5,850.0	1	5,850.0	100.0
Зөвлөмж	1	1,920.0	1	1,920.0	100.0
Нийт дүн	3	11,102.0	3	11,102.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар насжилт өндөртэй авлагыг цуглуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, урьдчилж орсон түрээсийн орлогын бүртгэлийн талаар горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 502.3 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 0.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 456.9 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 45.1 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 502.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 482.4 сая төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Байгууллагын хөрөнгөөр 0.3 сая төгрөгийн гар утасны төлбөрийг төлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1-д "гар утасны зардал" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж байгууллагын хөрөнгөөр гар утасны зардал төлсөн дүнг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд 74.2 сая төгрөгийн авлага, 181.6 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. ТӨБЗГ-аар батлуулсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллаагүй 201.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын дүрмийн 8 дугаар зүйлийн 8.12.8-д "төсөв, хөрөнгийг төвлөрүүлэх, хөрөнгийг үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд заасны дагуу захиран зарцуулах, төсөв санхүүгийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих" гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний төлөвлөгөөг биелүүлээгүй, алдагдалтай ажилласан зөрчлийг арилгаж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн зарлагын ажил гүйлгээг анхан шатны баримт руу тулган шалгахад баримт бүрдэл дутуу 45.1 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Мөнгөн зарлагын ажил гүйлгээний баримтын иж бүрдэлд хяналт тавьж, анхан шатны баримтад тулгуурлан ажил гүйлгээг бүртгэж байх.

2. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллага нь санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл, түүний тодруулгыг Сангийн сайдын баталсан журам, заавар аргачлалын дагуу иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилт түвшний гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын баталсан журам, заавар, аргачлалын дагуу үнэн зөв, иж бүрэн бэлтгэж ирүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2024 оны 09 дүгээр сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын хөрөнгөөр 0.3 сая төгрөгийн гар утасны төлбөрийг төлсөн байна.	1	259.2	1	259.2	-	-	-	-	-	-
Мөнгөн зарлагын ажил гүйлгээг анхан шатны баримт руу тулган шалгахад баримт бүрдэл дутуу 45.1 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна.	1	45,057.8	-	-	-	-	1	45,057.8	-	-
Тайлант хугацаанд 74.2 сая төгрөгийн авлага, 181.6 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	255,774.3	-	-	1	255,774.3	-	-	-	-
Байгууллага нь санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэл, түүний тодруулгыг Сангийн сайдын баталсан журам, заавар аргачлалын дагуу иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
ТӨБЗГ-аар батлуулсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллаагүй 201.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	1	201,182.6	-	-	1	201,182.6	-	-	-	-
Дүн	5	502,273.9	1	259.2	2	456,956.9	2	45,057.8	-	-

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Албан шаардлага		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Шилэн дансны цахим хуудаст байршуулбал зохих нийт 133 ажил гүйлгээнээс цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 118.9 сая төгрөгийн 13 ажил гүйлгээг байршуулаагүй байна.	1	118,957.7	1	118,957.7				
Дүн	1	118,957.7	1	118,957.7				

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 дугаар сарын 14 № 85/АД150061
СНАГ-2024/18/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын хөрөнгөөр 259,200.00 (хоёр зуун тавин есөн мянга хоёр зуун) төгрөгийн гар утасны төлбөрийг төлсөн байна.

Энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1-д "гар утасны зардал" гэж заасныг зөрчсөн байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж байгууллагын хөрөнгөөр гар утасны зардалд төлсөн 259,200.00 (хоёр зуун тавин есөн мянга хоёр зуун) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 10090000601 тоот дансанд төвлөрүүлэх,
- Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын захирал /Ж.Золзаяа/, ерөнхий нягтлан бодогч /Д.Цэрэндолгор/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Г.МӨНХБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 14 № 424/А0150061

Улаанбаатар хот

СНАГ-2024/18/НА-СТХ-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих нийт 133 ажил гүйлгээнээс цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 118,957,702.35 (нэг зуун арван найман сая есөн зуун тавин долоон мянга долоон зуун хоёр төгрөг гучин таван мөнгө) төгрөгийн 13 ажил гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг дутуу байршуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын захирал /Ж.Золзаяа/, ерөнхий нягтлан бодогч /Д.Цэрэндолгор/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Г.МӨНХБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 429/А0150061

Улаанбаатар хот

СИАГ-2024/18/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллаагүй 201,182,636.49 (хоёр зуун нэг сая нэг зуун наян хоёр мянга зургаан зуун гучин зургаан төгрөг дөчин есөн мөнгө) төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын дүрмийн 8 дугаар зүйлийн 8.12.8-д "төсөв, хөрөнгийг төвлөрүүлэх, хөрөнгийг үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд заасны дагуу захиран зарцуулах, төсөв санхүүгийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих" гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг биелүүлээгүй, алдагдалтай ажилласан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын захирал /Ж.Золзаяа/, ерөнхий нягтлан бодогч /Д.Цэрэндолгор/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Г.МӨНХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230



Z:\Alban Shaardlaga 2024\0314\SIAG-I Docx

0001000983



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 430/A0150061

Улаанбаатар хот

СНАГ-2024/18/НА-СТА-ТОА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 74,200,000.00 (далан дөрвөн сая хоёр зуун мянган) төгрөгийн авлага, 181,574,270.00 (нэг зуун наян нэгэн сая таван зуун далан дөрвөн мянга хоёр зуун далан) төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дүгээр зүйл 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын захирал /Ж.Золзаяа/, ерөнхий нягтлан бодогч /Д.Цэрэндолгор/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Г.МӨНХБАЯР

